# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 30 өдөр Дугаар А/224 Улаанбаатар хот

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
эргэлтийн бус хөрөнгийг
балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд нийт 4,244,268.60 (дөрвөн сая хоёр зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун жаран найман төгрөг жаран мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Зөөврийн компьютер і7 маркийн хөрөнгийг шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ерөнхий нягтлан бодогч (Г.Саранчимэг)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу данс бүртгэлдээ бүртгэн, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг "Монгол Наадам цогцолбор" ОНӨТҮГ (Д.Отгонбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА В.ОЮУМАА

1125010664

D:\lad\BL.Tushaal. docx

1425030505